

**ТӨСВИЙН ШУУД ЗАХИРАГЧИЙН
2020 ОНЫ САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛД
ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ**

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
АОУС	Аудитын Олон Улсын Стандарт
НДШ	Нийгмийн даатгалын шимтгэл
НБББББ	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг
ХАОАТ	Хүн амын орлогын албан татвар
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар

Агуулга

1	Аудит хийсэн санхүүгийн тайлан	1
2.1	Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан.....	1
2.2	Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан	3
2.3	Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан	5
2.4	Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан	7
2.5	Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан.....	8
2.6	Аудит хийсэн нэмэлт санхүүжилтийн тайлан.....	10
3.	Аудитын тайлан.....	11
3.1.	Ерөнхий зүйл.....	11
3.2.	Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүй.....	11
3.3	Нягтлан бодох бүртгэлийн үндсэн бодлого, дотоод хяналт	11
3.4.	Материаллаг байдал	12
3.5.	Санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүд.....	12
3.6.	Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл санхүүжилт.....	13
3.7.	Шилэн дансны мэдээлэл.....	14
3.8.	Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт	15
3.9.	Аудитын илрүүлэлт	15
3.10.	Балансын дараах үйл явдал болон дараагийн аудитаар авч үзэх анхаарал татахуйц бусад чухал асуудлууд.....	15
4.	Менежментийн захидал.....	16
5.	Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт	20



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг
Бага тойруу-3, Засгийн газрын IV байр
Утас:26-04-37, Факс:51-26-42-30
E-mail: info@audit.gov.mn

ГАЗАРЗҮЙ, ГЕО-ЭКОЛОГИЙН
ХҮРЭЭЛЭНГИЙН ЗАХИРАЛ
Д.БАТТОГТОХ ТАНАА

2021.02.25 № 07/572
танай _____ -ны № _____ -т

Аудитын санал дүгнэлт

Зөрчилгүй санал дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, 8.4, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Газар зүй, гео-экологийн хүрээлэнгийн 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Газар зүй, гео-экологийн хүрээлэнгийн 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл материаллаг алдаагүй, Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, Сангийн сайдын баталсан холбогдох журамд нийцүүлэн үнэн зөв, шударга илэрхийлсэн толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, гарын авлагын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Бусад мэдээлэл

Байгууллагын удирдлага бусад мэдээлэлтэй холбоотой үүрэг хариуцлагыг хүлээнэ. Байгууллагын жилийн гүйцэтгэлийн төлөвлөгөөнд 1 зорилтын хүрээнд 3 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөснөөс 98.9 хувийн гүйцэтгэлтэй гэж тайлагнасан байна.

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, Сангийн сайдын баталсан журам, зааврын дагуу үнэн зөв, шударга бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэж болох материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтуудыг хэрэгжүүлэх хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдаанаас үүссэн материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар түүнийг бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

АУДИТЫН ХОЁРДУГААР ГАЗРЫН ЗАХИРАЛ,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ц.НАРАНЧИМЭГ

Аудит хийсэн санхүүгийн тайлан

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл /Төгрөгөөр/
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	119,670,793.91	123,022,641.03
33	АВЛАГА	93,239,493.91	116,994,458.03
33100	Ажиллагсадтай холбогдсон авлага	0.00	1,139,897.00
33300	Татаас санхүүжилтийн авлага	93,239,493.91	115,854,561.03
35	БАРАА МАТЕРИАЛ	26,431,300.00	6,028,183.00
351	Түүхий эд материал	24,852,200.00	4,182,200.00
35110	Тусгай зориулалттай материал	24,852,200.00	4,182,200.00
354	Хангамжийн материал	1,579,100.00	1,845,983.00
35410	Бичиг хэргийн материал	734,700.00	930,639.00
35420	Аж ахуйн материал	194,800.00	235,144.00
35430	Сэлбэг хэрэгсэл	0.00	138,600.00
35440	Түлш шатах тослох материал	380,000.00	500,000.00
35470	Бусад хангамжийн материал	269,600.00	41,600.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	2,517,650,223.05	2,526,111,528.47
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	2,517,650,223.05	2,526,111,528.47
392	Биет хөрөнгө	1,960,796,142.93	1,969,334,448.33
39201	Барилга, байгууламж	1,856,422,808.30	1,856,422,808.30
39202	Хуримтлагдсан элэгдэл	(99,092,794.16)	(169,593,857.20)
39203	Авто тээврийн хэрэгсэл	66,476,124.00	75,950,000.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	(66,476,124.00)	(38,472,500.00)
39205	Машин, тоног төхөөрөмж	578,444,854.63	663,439,124.63
39206	Хуримтлагдсан элэгдэл	(445,721,874.65)	(488,041,436.87)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	207,286,419.35	209,987,219.35
39208	Хуримтлагдсан элэгдэл	(168,571,597.67)	(178,754,482.49)
39214	Бусад үндсэн хөрөнгө	48,586,060.00	48,586,060.00
39215	Хуримтлагдсан элэгдэл	(42,475,465.44)	(47,714,419.96)
39216	Дуусаагүй барилга, байгууламж	3,600,000.00	3,600,000.00
39217	Номын фонд	22,317,732.57	33,925,932.57
393	Биет бус хөрөнгө	556,854,080.12	556,777,080.14
39301	Програм хангамж	1,984,000.00	1,984,000.00
39302	Хасагдуулга	(1,225,999.88)	(1,302,999.86)
39303	Бусад биет бус хөрөнгө	556,096,080.00	556,096,080.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН	2,637,321,016.96	2,649,134,169.50
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ/ӨМЧИЙН ДҮН	2,637,321,016.96	2,649,134,169.50
51	Засгийн газрын хувь оролцоо	2,637,321,016.96	2,649,134,169.50
511	Засгийн газрын оруулсан капитал /ЗГСан/ орон нутгийн сан	1,741,521,060.73	1,741,521,060.73
51101	Өмч: -Төрийн өмч	1,741,521,060.73	1,741,521,060.73
512	Хуримтлагдсан үр дүн	(918,115,011.65)	(906,301,859.11)
51210	Өмнөх үеийн үр дүн	(918,115,011.65)	(918,115,011.65)

Газар зүй, гео-экологийн хүрээлэнгийн 2020 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

51220	Тайлант үеийн үр дүн	0.00	11,813,152.54
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	1,813,914,967.88	1,813,914,967.88
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ/ӨМЧИЙН ДҮН	2,637,321,016.96	2,649,134,169.50

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Дансны код	Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	/Төгрөгөөр/ Эцсийн үлдэгдэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	2,540,026,682.60	3,306,856,031.12
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	39,098,000.00	24,996,570.00
120	Нийтлэг татварын бус орлого	39,098,000.00	24,996,570.00
120004	Төсөвт байгууллагын өөрийн орлого	39,098,000.00	11,105,000.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	39,098,000.00	0.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	0.00	105,000.00
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	0.00	11,000,000.00
120017	Үнэ төлбөргүй хүлээн авсан Үндсэн хөрөнгө	0.00	13,891,570.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	2,500,928,682.60	3,281,859,461.12
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	1,932,655,100.00	2,503,385,500.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	1,932,655,100.00	2,503,385,500.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	568,273,582.60	778,473,961.12
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив тусламж	118,787,582.60	141,734,561.12
131104	Дээд шатны төсвийн захирагчаас төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захи	263,599,000.00	141,082,500.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	185,887,000.00	495,656,900.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН (II)	2,606,429,377.18	3,295,042,878.58
21	УРСГАЛ ЗАРДАЛ	2,606,429,377.18	3,295,042,878.58
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	2,600,577,679.18	3,210,944,627.97
2101	Цалин, хөлс болон нэмэгдэл урамшил	1,631,687,326.00	2,127,548,848.00
210101	Цалин	1,631,687,326.00	1,803,069,353.00
210102	Нэмэгдэл цалин	0.00	155,684,495.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	0.00	168,795,000.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	210,662,405.88	269,545,401.39
210201	Тэтгэврийн даатгалын шимтгэл	138,411,695.00	185,645,042.00
210202	Тэтгэмжийн даатгалын шимтгэл	16,283,730.00	21,864,767.00
210203	ҮОМШ өвчний даатгалын шимтгэл	16,134,658.00	17,038,210.00
210204	Ажилгүйдлийн даатгалын шимтгэл	5,256,613.90	5,027,755.39
210205	Эрүүл мэндийн даатгалын хураамж	34,575,708.98	39,969,627.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	46,500,688.00	50,068,016.00
210301	Гэрэл цахилгааны зардал	20,975,231.00	20,457,431.00
210302	Түлш, халаалтын зардал	20,897,100.00	26,136,245.00
210303	Цэвэр, бохир усны зардал	4,628,357.00	3,474,340.00
2104	Хангамж, бараа материалын зардал	95,914,652.40	59,032,756.00
210401	Бичиг хэргийн материал	22,079,330.40	21,568,172.00
210402	Тээвэр, шатахууны зардал	4,940,000.00	4,691,900.00
210403	Шуудан холбоо интернетийн төлбөр	2,459,856.00	2,188,874.00
210404	Ном, хэвлэлийн зардал	3,056,700.00	223,200.00
210405	Хог хаягдал устгах, цэвэрлэх	1,560,000.00	1,292,000.00
210406	Бага үнэ түргэн элэгдэл зүйлс	30,618,166.00	20,361,310.00
210407	Аж ахуйн материал худалдан авах зардал	31,200,600.00	8,707,300.00

Газар зүй, гео-экологийн хүрээлэнгийн 2020 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

2106	Эд хогшил, урсгал засварын зардал	30,158,922.00	59,517,225.00
210601	Багаж хэрэгсэл	3,315,000.00	5,400,000.00
210604	Урсгал засвар	26,843,922.00	54,117,225.00
2107	Томилолт, зочны зардал	858,210.00	5,425,750.00
210702	Дотоод томилолтын зардал	858,210.00	5,425,750.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр хураамж	385,753,377.00	393,273,499.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	378,489,753.00	385,063,979.00
210802	Аудит, баталгаажуулалт зэрэглэл тогтоох зардал	2,500,000.00	2,300,000.00
210803	Даатгалын үйлчилгээний төлбөр	307,368.00	326,700.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	533,500.00	407,480.00
210805	Тээврийн хэрэгслийн оношилгоо	73,000.00	99,000.00
210807	Газрын төлбөр	3,849,756.00	5,076,340.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	199,042,097.90	246,533,132.58
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	14,468,000.00	117,511,168.00
210902	Хичээл сургалт, үйлдвэрлэлийн дадлагын зардал	4,430,600.00	480,000.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	180,143,497.90	128,541,964.58
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	5,851,698.00	84,098,250.61
2132	Бусад урсгал шилжүүлэг	5,675,352.00	7,328,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж шагнал урамшуулал	5,675,352.00	7,328,000.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	176,346.00	76,770,250.61
213301	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	0.00	76,770,250.61
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	176,346.00	0.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	0.00	0.00
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III=I-II)	(66,402,694.58)	11,813,152.54
4	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (VI=IV-V)	0.00	0.00
5	НИЙТ ҮР ДҮН (VII=III+VI)	(66,402,694.58)	11,813,152.54

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

/Төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)	2,540,026,682.60	3,375,203,955.03
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	39,098,000.00	105,000.00
120	Нийтлэг татварын бус орлого	39,098,000.00	105,000.00
120004	Төсөвт байгууллагын өөрийн орлого	39,098,000.00	105,000.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	39,098,000.00	0.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	0.00	105,000.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	2,500,928,682.60	3,375,098,955.03
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	1,932,655,100.00	2,503,385,500.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	1,932,655,100.00	2,503,385,500.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	568,273,582.60	871,713,455.03
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив тусламж	118,787,582.60	204,644,561.12
131104	Дээд шатны төсвийн захирагчаас төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захи	263,599,000.00	141,082,500.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	185,887,000.00	525,986,393.91
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (II)	2,508,227,282.60	3,287,944,455.03
21	УРСГАЛ ЗАРДАЛ	2,508,227,282.60	3,287,944,455.03
210	БАРАА АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	2,406,911,442.69	3,087,991,643.39
2101	Цалин, хөлс болон нэмэгдэл урамшил	1,576,376,398.00	1,970,393,577.00
210101	Үндсэн цалин	1,486,852,318.00	1,494,517,887.00
210102	Нэмэгдэл	61,044,360.00	308,308,690.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	28,479,720.00	167,567,000.00
2102	Ажил олгочоос нийгтийн даатгалд төлөх шимтгэл	204,507,300.00	256,306,887.39
210201	Тэтгэврийн даатгалын шимтгэл	119,928,900.00	178,920,120.30
210202	Тэтгэмжийн даатгалын шимтгэл	33,866,600.00	20,718,551.47
210203	ҮОМШ өвчний даатгалын шимтгэл	14,070,600.00	16,250,995.68
210204	Ажилгүйдлийн даатгалын шимтгэл	14,070,600.00	3,766,194.22
210205	Эрүүл мэндийн даатгалын хураамж	22,570,600.00	36,651,025.72
2103	Байр ашиглалтай холбоотой тогтмол зардал	46,434,488.00	49,655,420.00
210301	Гэрэл цахилгааны зардал	18,809,116.00	20,099,535.00
210302	Түлш, халаалтын зардал	22,997,015.00	26,136,245.00
210303	Цэвэр, бохир усны зардал	4,628,357.00	3,419,640.00
2104	Хангамж, бараа материалын зардал	12,451,200.00	13,956,295.00
210401	Бичиг хэрэг	2,172,890.40	2,606,100.00
210402	Тээвэр, шатахуун	2,399,877.00	1,897,000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	2,230,879.00	2,211,913.00
210404	Ном, хэвлэл	1,996,400.00	2,021,160.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	1,560,000.00	1,292,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	2,091,153.60	3,928,122.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	30,000,000.00	25,330,000.00
210601	Багаж техник хэрэгсэл	0.00	330,000.00

Газар зүй, гео-экологийн хүрээлэнгийн 2020 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

210604	Урсгал засвар	30,000,000.00	25,000,000.00
2107	Томилолт, зочны зардал	22,302,500.00	9,979,750.00
210702	Дотоод албан томилолт	22,302,500.00	9,979,750.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	496,371,556.69	610,705,256.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил, үйлчилгээний төлбөр хураамж	490,517,188.69	602,495,736.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	2,500,000.00	2,300,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	307,368.00	326,700.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	467,500.00	457,480.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	139,000.00	99,000.00
210807	Газрын төлбөр	2,440,500.00	5,026,340.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	18,468,000.00	151,664,458.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	14,468,000.00	151,184,458.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлаг хийх	4,000,000.00	480,000.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	101,315,839.91	199,952,811.64
2132	Бусад урсгал шилжүүлэг	7,900,000.00	7,328,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж шагнал урамшуулал	7,900,000.00	7,328,000.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	93,415,839.91	192,624,811.64
213301	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	0.00	76,770,250.61
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	176,346.00	0.00
213305	Төвлөрүүлэх шилжүүлэг / Нэмэлт санхүүжилт/	93,239,493.91	115,854,561.03
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)	31,799,400.00	87,259,500.00
	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	0.00	0.00
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (V)	31,799,400.00	87,259,500.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	31,799,400.00	87,259,500.00
2200	Дотоод эх үүсвэрээр	31,799,400.00	87,259,500.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	31,799,400.00	87,259,500.00
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V)	(31,799,400.00)	(87,259,500.00)
	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	0.00	0.00
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	0.00	0.00
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	0.00	0.00
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	0.00	0.00

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

/төгрөгөөр/

Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
2018 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	1,741,521,060.73	1,813,914,967.88	(779,790,356.00)	2,775,626,072.61
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	(71,921,661.07)	(71,921,661.07)
Дахин илэрхийлсэн үлдэгдэл	1,741,521,060.73	1,813,914,967.88	(851,712,317.07)	2,703,704,411.54
Тайлант үеийн үр дүн	-	-	(66,402,694.58)	(66,402,694.58)
2019 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	1,741,521,060.73	1,813,914,967.88	(918,115,011.65)	2,637,321,016.96
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	-	-
Дахин илэрхийлсэн үлдэгдэл	1,741,521,060.73	1,813,914,967.88	(918,115,011.65)	2,637,321,016.96
Тайлант үеийн үр дүн	-	-	11,813,152.54	11,813,152.54
2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	1,741,521,060.73	1,813,914,967.88	(906,301,859.11)	2,649,134,169.50

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

/Төгрөгөөр/

Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	0.00	0.00	0.00	0.00
НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	2,503,385,500.00	2,426,720,249.39	(76,665,250.6)	96.9
УРСГАЛ ЗАРДАЛ	2,503,385,500.00	2,426,720,249.39	(76,665,250.6)	96.9
БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	2,495,146,500.00	2,419,392,249.39	(75,754,250.6)	97.0
Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	2,007,019,400.00	1,970,393,577.00	(36,625,823.0)	98.2
Үндсэн цалин	1,443,357,000.00	1,494,517,887.00	51,160,887.0	103.5
Нэмэгдэл	329,230,400.00	308,308,690.00	(20,921,710.0)	93.6
Унаа хоолны хөнгөлөлт	234,432,000.00	167,567,000.00	(66,865,000.0)	71.5
Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	278,507,600.00	256,306,887.39	(22,200,712.6)	92.0
Тэтгэврийн даатгал	195,986,800.00	178,920,120.30	(17,066,679.7)	91.3
Тэтгэмжийн даатгал	20,630,200.00	20,718,551.47	88,351.5	100.4
ҮОМШӨ-ний даатгал	16,504,200.00	16,250,995.68	(253,204.3)	98.5
Ажилгүйдлийн даатгал	4,126,000.00	3,766,194.22	(359,805.8)	91.3
Эрүүл мэндийн даатгал	41,260,400.00	36,651,025.72	(4,609,374.3)	88.8
Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	59,431,500.00	49,655,420.00	(9,776,080.0)	83.6
Гэрэл, цахилгаан	20,956,000.00	20,099,535.00	(856,465.0)	95.9
Түлш, халаалт	34,614,500.00	26,136,245.00	(8,478,255.0)	75.5
Цэвэр, бохир ус	3,861,000.00	3,419,640.00	(441,360.0)	88.6
Хангамж, бараа материалын зардал	16,615,500.00	14,095,295.00	(2,520,205.0)	84.8
Бичиг хэрэг	2,615,000.00	2,615,000.00	0.0	100.0
Тээвэр, шатахуун	1,779,000.00	1,897,000.00	118,000.0	106.6
Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	2,579,500.00	2,211,913.00	(367,587.0)	85.7
Ном, хэвлэл	2,230,000.00	2,151,260.00	(78,740.0)	96.5
Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	2,592,000.00	1,292,000.00	(1,300,000.0)	49.8
Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	4,820,000.00	3,928,122.00	(891,878.0)	81.5
Эд хогшил, урсгал засварын зардал	49,500,000.00	48,500,000.00	(1,000,000.0)	98.0
Багаж, техник, хэрэгсэл	23,500,000.00	23,500,000.00	0.0	100.0
Урсгал засвар	26,000,000.00	25,000,000.00	(1,000,000.0)	96.2
Томилолт, зочны зардал	10,000,000.00	9,979,750.00	(20,250.0)	99.8
Дотоод албан томилолт	10,000,000.00	9,979,750.00	(20,250.0)	99.8
Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	70,372,500.00	69,981,320.00	(391,180.0)	99.4
Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	61,773,300.00	61,771,800.00	(1,500.0)	100.0
Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	2,500,000.00	2,300,000.00	(200,000.0)	92.0
Даатгалын үйлчилгээ	326,700.00	326,700.00	0.0	100.0
Тээврийн хэрэгслийн татвар	467,500.00	457,480.00	(10,020.0)	97.9
Тээврийн хэрэгслийн оношлогоо	165,000.00	99,000.00	(66,000.0)	60.0

Газар зүй, гео-экологийн хүрээлэнгийн 2020 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

Газрын төлбөр	5,140,000.00	5,026,340.00	(113,660.0)	97.8
Бараа үйлчилгээний бусад зардал	3700000.00	480000.00	(3,220,000.0)	13.0
Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	3,700,000.00	480,000.00	(3,220,000.0)	13.0
УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	8239000.00	7328000.00	(911,000.0)	88.9
Бусад урсгал шилжүүлэг	8,239,000.00	7,328,000.00	(911,000.0)	88.9
Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	8,239,000.00	7,328,000.00	(911,000.0)	88.9
ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	2,503,385,500.00	2,426,720,249.39	(76,665,250.6)	96.9
УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	2,503,385,500.00	2,426,720,249.39	(76,665,250.6)	96.9
Улсын төсвөөс санхүүжих	2,503,385,500.00	2,426,720,249.39	(76,665,250.6)	96.9
АЖИЛЛАГСАДЫН ТОО	158	158	0.0	100.0
Удирдах ажилтан	1	1	0.0	100.0
Гүйцэтгэх ажилтан	133	133	0.0	100.0
Үйлчлэх ажилтан	24	24	0.0	100.0

2.6 Аудит хийсэн нэмэлт санхүүжилтийн тайлан

Үзүүлэлт	/Төгрөгөөр/	
	Төлөвлөгөө	Гүйцэтгэл
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		-
НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	-	871,713,455.03
УРСГАЛ ЗАРДАЛ	-	871,713,455.03
БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	-	755,858,894.00
Эд хогшил, урсгал засварын зардал	-	26,700,000.00
Багаж, техник, хэрэгсэл	-	26,700,000.00
Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	-	545,146,436.00
Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	-	545,146,436.00
Бараа үйлчилгээний бусад зардал	-	184,012,458.00
Бараа үйлчилгээний бусад зардал	-	184,012,458.00
УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	-	115,854,561.03
Төвлөрүүлэх шилжүүлэг / Нэмэлт санхүүжилт/	-	115,854,561.03
ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	-	871,713,455.03
Нэмэлт санхүүжилтийн орлого	-	871,713,455.03
Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	-	204,644,561.12
Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	-	141,082,50-
Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	-	525,986,393.91
НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(II)-(I)	-	-
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	-
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	-

3. Аудитын тайлан

3.1. Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасан бүрэн эрхийн хүрээнд дагуу Газар зүй, гео-экологийн хүрээлэнгийн 2020 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын дүгнэлтийг Д.Баттогтох танд танилцуулж байна.

Энэхүү тайланд шалгагдагч этгээдийн санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтад хийсэн үнэлгээ, аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал бүхий аудитын дүгнэлт түүний үндэслэлийн талаар тус тус хураангуйлан толилуулав.

Аудитын тайланд шалгагдагч этгээдэд шилэн дансны хуулийн хэрэгжилтийг хангах, авлага, өр төлбөр үүсгэхгүй байх талаар өгсөн зөвлөмжүүдийг менежментийн захидалд тусгасан болно.

Аудитыг 2021 оны 01 дүгээр сарын 04-нөөс 2021 оны 02 дугаар сарын 25-ны хооронд “Гроут финанс Аудит” ХХК-ийн захирал Б.Бямба, аудитор Б.Даваасүрэн, туслах аудитор Т.Гантуул нар хариуцаж хэрэгжүүлэв.

Газар зүй, гео-экологийн хүрээлэнгийн 2020 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг Гроут финанс Аудитад 2021 оны 01 сарын 20-ны өдрийн 1/10 дугаар бүхий албан бичгээр ирүүлсэн байна.

3.2. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүй

Газар зүй, гео-экологийн хүрээлэнгийн үйл ажиллагааны зорилгыг дараах байдлаар тодорхойлжээ. Үүнд:

- Даян дэлхийн өөрчлөлтийн Монгол орны байгаль, нийгэм, эдийн засагт үзүүлэх нөлөөг судлах, салбар дундын инновацийн шийдлийг хөгжүүлэх, мэдлэгийн менежментийг хэрэгжүүлэх замаар тогтвортой хөгжлийг түгээхэд
- Даян дэлхийн өөрчлөлт байгалийн нөөц, баялаг болон хүн амын амьдрал ахуйд үзүүлэх нөлөөг судлах, үнэлэх, зураглах
- Байгаль хамгаалал, байгалийн нөөцийн тогтвортой менежментийг бүрдүүлэхэд шаардлагатай технологи, инновацийг турших, нэвтрүүлэх, дамжуулах;
- Бүх нийтийн байгаль орчны мэдлэг, байгалийг зүй зохистой ашиглах, хамгаалах сэтгэлгээг хөгжүүлэх

Газар зүй, гео-экологийн хүрээлэнгийн нь өнөөдөр суурь болон хавсрага судалгааны ажлыг 10 салбар, 3 лабораторийн бүтэцтэйгээр нийт 158 эрдэм шинжилгээний ажилтны бүрэлдэхүүнтэйгээр үйл ажиллагаа явуулж байна.

Тайлант хугацаанд байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд мөрддөг хууль, тогтоомж, бодлого, журамд томоохон өөрчлөлт ороогүй байна.

3.3 Нягтлан бодох бүртгэлийн үндсэн бодлого, дотоод хяналт

Газар зүй, гео-экологийн хүрээлэнгийн санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангаа Төсвийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв бэлтгэх үүрэгтэй.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг нягтлан бодох бүртгэлийн бодлого, холбогдох стандарт, хууль тогтоомжийн дагуу бэлтгэгдсэн ч байгууллагын үйл ажиллагаатай онцлогтой нийцээгүй байна.

Боловсрол шинжлэх ухааны яамны Хяналт, шинжилгээ, үнэлгээ дотоод аудитын газар 2020 онд Газар зүй, гео-экологийн хүрээлэнгийн санхүүгийн үйл ажиллагаанд дотоод аудит хийгээгүй байна.

Газар зүй, гео-экологийн хүрээлэнгийн дотоод хяналтын эрсдэлийг төлөвлөлтийн үе шатанд бага гэж үнэлсэн бөгөөд гүйцэтгэлийн үе шатанд дахин хянахад дотоод хяналт үр нөлөөтэй гэж үзлээ.

3.4. Материаллаг байдал

Аудитыг төлөвлөх болон гүйцэтгэх үе шатны материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2020 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлыг сонгож, эрсдэлийн түвшинг “бага” гэж үнэлэн материаллаг байдлын хувь хэмжээг 1 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн үе шатанд материаллаг байдлын түвшинг 2020 эхний хагас жилийн санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардал 1,640,249.2 мянган төгрөгөөс 1 хувиар буюу 16,402.5 мянган төгрөгөөр материаллаг байдлыг тодорхойлж, баталгаажууллаа.

Гүйцэтгэлийн үе шатанд төлөвлөлтийн үе шатанд сонгосон суурийг хэвээр авч 2020 оны жилийн эцсийн санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардал 3,295,042.9 мянган төгрөгөөс 1 хувиар буюу 32,950.4 мянган төгрөгөөр тооцон авлаа.

3.5. Санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүд

Газар зүй, гео-экологийн хүрээлэнгийн 2020 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 11,813.2 мянган төгрөгөөр буюу 0.5 хувиар өссөн байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан авлага, бараа материал, үндсэн хөрөнгө, засгийн газрын оролцоо данс байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөг/

Дансны нэр	Тайлант оны эхний үлдэгдэл	Тайлант оны эцсийн үлдэгдэл	Зөрүү	
			Дүн	Хувь
2	3	4	5	6
ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	119,670.8	123,022.6	3,351.9	2.8
МӨНГӨН ХӨРӨНГӨ	-	-	-	-
АВЛАГА	93,239.5	115,854.6	23,755.0	25.5
БАРАА МАТЕРИАЛ	26,431.3	6,028.2	(20,403.1)	(77.2)
ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	2,517,650.2	2,526,111.5	8,461.3	0.3
ҮНДСЭН ХӨРӨНГӨ	2,517,650.2	2,526,111.5	8,461.3	0.3
НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН	2,637,321.0	2,649,134.2	11,813.2	0.5
НИЙТ ӨР ТӨЛБӨР	-	-	-	-
ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	2,637,321.0	2,649,134.2	11,813.2	0.5
ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	2,637,321.0	2,649,134.2	11,813.2	0.5

Авлага дансны үлдэгдэл 116,994.5 мянган төгрөг болж 23,755.0 мянган төгрөгөөр өссөн нь эрдэм шинжилгээний үргэлжилж байгаа төслийн санхүүжилтийн авлагаар нэмэгдсэн байна.

Бараа материалын дансны үлдэгдэл 6,028.2 мянган төгрөг болж 20,403.1 мянган төгрөгөөр буурсан нь тусгай зориулалтын материалын үлдэгдлээс 24,852.2 мянган төгрөгийн материалыг үндсэн хөрөнгөнд шилжүүлсэн. Төсвийн хөрөнгөөр 97,084.5 мянга төгрөгийн бараа материал худалдан авч, 92,635.4 мянган төгрөгийн материалыг зарцуулсан.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 2,526,111.5 мянган төгрөг болж 8,461.3 мянган төгрөгөөр өссөн нь урсгал төсвийн хөрөнгөөр 112,620.3 мянган төгрөгийн үндсэн хөрөнгө, худалдан авч, хандиваар тусламжаар 24,383.0 мянган төгрөгийн үндсэн хөрөнгө үнэ төлбөргүй хүлээн авч данс бүртгэлд тусгасан байна.

Тайлант онд ТӨБЗГ-ын 2019 оны 518 дугаар тогтоолоор 28,226.1 мянган төгрөгийн үндсэн хөрөнгө акталж данс бүртгэлээс хассан, 128,542.0 мянган төгрөгийн элэгдлийн зардал тооцсонтой холбоотой байна.

Биет бус хөрөнгө нэмэгдээгүй, 77.0 мянган төгрөгийн элэгдлийн зардлаар буурсан байна.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 2,649,134.2 мянган төгрөг болж 11,813.2 мянган төгрөгөөр өссөн нь тайлант жилийн үр дүнгээр нэмэгдсэн байна.

Газар зүй, гео-экологийн хүрээлэнгийн санхүүгийн үр дүнгийн тайлангаар нийт орлого өмнөх оноос 791,681.6 мянган төгрөгөөр буюу 31.2 хувиар өссөн нь Шинжлэх ухааны академиас санхүүжих санхүүжилт 570,730.4 мянган төгрөг, нэмэлт төсвийн санхүүжилт 210,200.4 мянган төгрөг, төсвийн байгууллагын өөрийн орлого 10,750.8 мянган төгрөгөөр тус тус өссөнтэй холбоотой байна.

Нийт зардал өмнөх оноос 688,613.5 мянган төгрөгөөр буюу 26.4 хувиар өссөн нь Цалин хөлс, нэмэгдэл урамшил, нийгмийн даатгалын зардал 554,744.5 мянган төгрөг, эд хогшил, урсгал засварын зардал 29,358.3 мянган төгрөг, бараа үйлчилгээний бусад зардал 47,491.0 тус бүр өссөнтэй холбоотой байна.

3.6. Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл санхүүжилт

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

Газар зүй, гео-экологийн хүрээлэн нь 2020 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг 2,700,122.0 мянган төгрөгөөр, нийт зарлагыг 2,700,122.0 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн захирагчийн хүргүүлсэн төсвийн төслөөс 198,736.5 мянган төгрөгөөр бууруулж 2,503,385.5 мянган төгрөгөөр батлагдсан байна. Дээрхи төсвөөс Цалин хөлс, НДШ-ийн зардал 50,521.8 мянган төгрөг, бичиг хэрэг, хангамжийн материалын зардлыг 13,460.7 мянган төгрөг, дотоод томилолтын зардлыг 32,290.0 мянган төгрөг, бусдаар гүйцэтгүүлсэн зардал 4,771.0 мянган төгрөг, Урсгал засвар, тоног төхөөрөмжийн зардлыг 97,693.0 мянган төгрөгөөр тус тус бууруулж баталсан нь Ковид-19 цар тахлын улмаас улсын хэмжээнд шинжилгээ судалгааны ажлыг багасгасантай холбоотой байна.

Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд төсвийн захирагчийн хэрэгжүүлэх үндсэн үйл ажиллагааны нэг хөтөлбөрийн төсөл гурван арга хэмжээг санхүүжүүлэхээр 2,503,385.5 мянган төгрөгийн төсөв баталснаас 100 хувь улсын төсвөөс санхүүжүүлэхээр төлөвлөжээ.

Гүйцэтгэлээр улсын төсвөөс 2,503,385.5 мянган төгрөгийн санхүүжилт авч, бусад орлого 105.0 мянган төгрөг нийт 2,503,490.5 мянган төгрөгийн орлого бүрдүүлж, урсгал үйл ажиллагаанд 2,426,720.2 мянган төгрөгийг зарцуулж 76,770.3 мянган төгрөгийг улсын төсөвт буцаан төвлөрүүлсэн байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 2,426,720.2 мянган төгрөг буюу 96.9 хувьтай байгаа нь Цалин хөлс болон нийгмийн даатгалын шимтгэлийн зардлыг 58,826.5 мянган төгрөгөөр, байр ашиглалттай холбоотой тогтмол зардлыг 9,776.1 мянган төгрөгөөр, бараа үйлчилгээний бусад зардлыг 3,220.0 мянган төгрөгөөр, хангамж, бараа материалын зардлыг 2,520.2 мянган төгрөгөөр, тус тус дутуу зарцуулсантай холбоотой байна.

Д/Д	Хөтөлбөр, арга хэмжээний		Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Биелэлт
	Код	Нэр				
1	80101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	2,007,019.4	1,970,393.6	36,625.8	98.2
1.1	80101	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	278,507.6	256,306.9	22,200.7	92.0
1.2	80101	Байр ашиглалтын үйлчилгээ	59,431.5	49,655.4	9,776.1	83.6
1.3	80101	Бараа үйлчилгээний бусад зардал	3,700.0	480.0	3,220.0	84.8
1.4	80101	Хангамж, бараа материалын зардал	16,615.5	14,095.3	2,520.2	13.0

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр харуулсан мэдээллийг энэ тайлангийн 2.5-д харуулав.

Нэмэлт санхүүжилт

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Нэмэлт санхүүжилтийн дансанд эрдэм шинжилгээний төслийн орлого 834,286.1 мянга, шинжилгээний төлбөрийн орлого 45,929.7 мянган төгрөгийн нийт 871,713.5 мянган төгрөгийг орлогыг бүрдүүлжээ.

Үүнээс бараа, ажил үйлчилгээний бусад зардалд нийт 755,858.9 мянган төгрөгийг зарцуулж, 115,854.6 мянган төгрөгийг улсын төсөвт буцаан төвлөрүүлсэн байна.

3.7. Шилэн дансны мэдээлэл

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор батлагдсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Тайлант хугацаанд оруулбал зохих 269 мэдээллээс хугацаандаа оруулсан 160 мэдээлэл, хугацаа хоцроосон 81 мэдээлэл байршуулж, байршуулаагүй 28 мэдээлэл байна. Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт 75 хувьтай байна

3.8. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн 17,753.7 мянган төгрөгийн 5 зөвлөмжийн хэрэгжилт 100 хувьтай байна.

Хүснэгт 3 Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн төлбөрийн акт, албан шаардлагын хэрэгжилт

/мянган.төгрөг/

Үзүүлэлт	Өмнөх оны илрүүлэлт		Биелэлт		Зөрүү		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Зөвлөмж	5	17,753.7	5	17,753.7	-	-	-
Нийт дүн	5	17,753.7	5	17,753.7	-	-	-

3.9. Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт 96,550.9 мянган төгрөгийн алдаа зөрчил илэрснээс, 66,902.1 мянган төгрөгийн алдааг залруулж, 29,648.8 мянган төгрөгийн алдаа зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх 5 зөвлөмж өглөө.

Залруулсан алдаа

Аудитаар нягтлан бодох бүртгэлийн бичилт, тооцоолол болон тайлагналын алдаатай дараах залруулгыг санхүүгийн тайланд тусгаж, баталгаажуулав. Үүнд

Үндсэн хөрөнгийн дансанд хэрэгжүүлсэн горим сорилын үр дүнд алдаатай тооцсон 66,902.1 мянган төгрөгийн элэгдлийн зардлыг залруулав.

Зөвлөмж өгөхөөс бусад байдлаар шийдвэрлэсэн алдаа, зөрчил

Аудитаар шилэн дансны зөрчлийг арилгах албан шаардлага хүргүүлсэн.

Аудитын зөвлөмж

Аудитаар илэрсэн 29,648.8 мянган төгрөгийн алдаа, зөрчилд 7 зөвлөмж өгч, менежментийн захидалд тусгав.

3.10. Балансын дараах үйл явдал болон дараагийн аудитаар авч үзэх анхаарал татахуйц бусад чухал асуудлууд

Газар зүй, гео-экологийн хүрээлэн нь эрдэм шинжилгээний төслийн хүрээнд бий болсон хөвөнгүүдийн тухайн төслийн зардалд шууд зарцуулснаар тайлагнаж байгаа нь байгууллагын үйл ажиллагааны хүрээнд ашиглагдаж байгаа хөрөнгүүдэд бүртгэлээр тавих хяналтгүй болгож байна.

4. Менежментийн захидал

Менежментийн захидалд цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлоор нь эрэмбэлэн үзүүлэв. Үүнд:

1. Зардлын данстай холбоотой асуудал

1.1 Илрүүлэлт:

Үндсэн хөрөнгийн тайлант оны элэгдлийн зардлыг 5,178.3 мянган төгрөгөөр илүү тооцон зардалд тусгагдсан. Энэ нь тайланд онд ашиглалтын жил дуусаж байгаа хөрөнгүүд дээр санхүүгийн програм элэгдлийг илүү тооцсон байна.

Энэ нь үнэлгээ, үнэн зөв байдал, хэмжилт батламж мэдэгдэлтэй нийцэхгүйгээс гадна Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалын 1 дүгээр хавсралт 4.35 Элэгдэл нь хөрөнгийн ашиглалтын хугацааны туршид элэгдүүлэх дүнг системтэйгээр хуваарилсан хуваарилалтыг хэлнэ гэсэнтэй, УСНББОУС-17 Үндсэн хөрөнгө 66-тай нийцэхгүй байна.

1.2 Эрсдэл:

Элэгдлийн зардал илүү тусгагдан тайлант оны үр дүн буурах

1.3 Өгсөн зөвлөмж:

Санхүүгийн програмын тооцооллыг нягталж байх, мөн санхүүгийн програмын үндсэн хөрөнгийн бүртгэлд сайжруулалт хийж, Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалын холбогдох заалтыг мөрдөж ажиллах.

1.4 Байгууллагаас өгсөн хариу, тайлбар:

Зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллана

2. Балансын данстай холбоотой асуудал

2.1 Илрүүлэлт:

Үндсэн хөрөнгөнд элэгдэл хорогдлын шимтгэлээр анхны үнээ нөхсөн 260 нэр төрлийн 886 ширхэг 719,248.5 мянган төгрөгийн хөрөнгө бүртгэлтэй байна

Энэ нь үнэн зөв байдал, иж бүрэн байх, эрх ба үүрэг, оршин байх батламж мэдэгдэлтэй нийцэхгүйгээс гадна Төрийн өмчийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 31-р зүйлийн 3-2.-той нийцэхгүй байна.

2.2 Эрсдэл:

Хөрөнгө санхүүгийн тайланд бодит үнэ цэнээрээ илэрхийлэгдэхгүй байх.

2.2 Өгсөн зөвлөмж:

Төрийн өмчийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 31-р зүйлийн 3-т 2.илүүдэл эд хөрөнгө болон элэгдэл хорогдлын шимтгэлээ анхны үнийг нөхсөн түүнчлэн нөхөөгүй боловч гэмтэж засаж сэлбээд өөр зориулалтаар ашиглаж болох эд хөрөнгийн үнийг ТӨБЗГ-тай зөвшилцөж шийдвэрлэх.

2.4 Байгууллагаас өгсөн хариу, тайлбар:

Дахин үнэлгээ хийлгэх саналаа ТӨБЗГ-т хүргүүлж ажиллана.

3. Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийн талаар

3.1 Илрүүлэлт:

Тус байгууллагын мөрдөж байгаа НБББББ нь өөрийн үйл ажиллагааны онцлогт тохироогүй байна. Тухайлбал эрдэм шинжилгээний төслийн санхүүжилт болон зарцуулалтыг хэрхэн бүртгэх талаар тусгаж өгөөгүй байгаа нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.2. "Аж ахуйн нэгж, байгууллагын удирдлага нь нягтлан бодох бүртгэлийн хууль тогтоомж, стандарт, дүрэм, журам, зааварт нийцүүлэн нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг баталж, мөрдөж ажиллана" гэсний дагуу НБББББ-т өөрчлөлт сайжруулалт хийх.

3.2 Эрсдэл:

НБББББ нь тухайн байгууллагын үйл ажиллагааны чиглэлтэй уялдуулаагүйгээс байгууллагын онцлогтой холбоотой бүртгэл тайлагнахыг буруу илэрхийлэх.

3.3 Өгсөн зөвлөмж:

Байгууллагын үйл ажиллагааны онцлог, чиглэлтэй уялдуулж бодлогын баримт бичгийг боловсруулж, мөрдөж ажиллах, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.2 дахь заалтыг хэрэгжүүлж ажиллах.

3.4 Байгууллагаас өгсөн хариу, тайлбар:

2021 онд НБББББ баримт бичгийг эцэслэн дуусгах мөн, шинээр салбарын НБББББ-ын баримт бичиг тусгуулан ажиллаж байгаа.

4 Бараа материалын данстай холбоотой асуудал

4.1 Илрүүлэлт:

Автомашин шатахууны зарцуулалтыг жолоочийн тооцооны хуудсыг үндэслэн тооцоо бодоогүй, мөн албан ажлын хэрэгцээнд хувийн автомашинд 1,897.0 мянган төгрөгийн байгууллагын шатахууны зарцуулсан нь Засгийн газрын 2015 оны 184 дүгээр тогтоолын 2. "Албан тушаалын автомашин хэрэглэх эрх бүхий албан тушаалтан суудлын автомашины хотын дотор хуанлийн хоног (баярын болон долоо хоногийн амралтын өдрийг оролцуулан)-т дунджаар 70 км, албан ажлын хэрэгцээний автомашин хэрэглэх эрх бүхий албан тушаалтан суудлын автомашины хотын дотор ажлын хоногт дунджаар 50 км, дуудлагын автомашины хөдөлгүүрийн цилиндрийн багтаамж 2500 см³-ээс илүүгүй байхаар тогтоож, ажлын хоногт дунджаар 40 км-ээс тус тус хэтрүүлэхгүй хэрэглэж байхаар тогтоосугай" гэсэн, мөн Зам, тээврийн хөгжлийн сайдын 2019 оны 390 дугаар тушаалын 1 дүгээр хавсралт "Автомашин 100 км гүйлтэд зарцуулах шатахуун зарцуулалтын жишиг норм"-той нийцэхгүй байна.

4.2 Эрсдэл:

Шатахууныг илүү дутуу зарцуулагдах, дутагдах

4.3 Өгсөн зөвлөмж:

Шатахууны зарцуулалтад тавих хяналтыг сайжруулж, Зам, тээврийн хөгжлийн сайдын 2019 оны 390 дугаар тушаалыг мөрдөж ажиллах.

4.4 Байгууллагаас өгсөн хариу, тайлбар:

Зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллана

5 Анхан шатны баримттай холбоотой асуудал

5.1 Илрүүлэлт:

Анхан шатны бүрдэл дутуу баримтаар нийт 7,630.5 мянган зардлыг бүртгэсэн. Томилолтын зардлын зарим баримт дутуу, үндсэн хөрөнгийн орлого, зарлагын баримт үйлдээгүй, шаардах хуудасгүй бараа материалыг зардалд бичсэн, үндсэн хөрөнгө, бараа материалын тайланг жилд нэг удаа гаргаж байгаа нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.7."Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно" заалттай нийцэхгүй байна.

5.2 Эрсдэл:

Байгууллагын эд хөрөнгөнд бүртгэлээр тавих хяналт суларч, хөрөнгө дутагдах

5.3 Өгсөн зөвлөмж:

Анхан шатны баримтын бүрдүүлэлтэд тавих хяналтыг сайжруулах, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.7 дахь заалтыг хэрэгжүүлж ажиллах.

5.4 Байгууллагаас өгсөн хариу, тайлбар:

ТШЗ-ийн зүгээс зөрчлийг цаашид давтан гаргахгүй ажиллах талаар хариу ирүүлсэн.

6 Хуулийн хэрэгжилтийн талаар

6.1 Илрүүлэлт:

Гэрээт ажлын хөлснөөс НДШ суутгаагүй, байгууллага төлөх НДШ-ийн зардал тооцоогүйгээс нийт 14,942.9 мянган төгрөгийн НДШ-ийг ногдуулж төлөөгүй нь Нийгмийн даатгалын тухай хуулийн 32 дугаар зүйл."Нийгмийн даатгалын шимтгэл ногдуулах хөдөлмөрийн хөлс, түүнтэй адилтгах орлого" заалттай нийцэхгүй байна.

6.2 Эрсдэл:

Хууль журам мөрдөөгүйгээс хүү торгууль тооцогдох

6.3 Өгсөн зөвлөмж:

Нийгмийн даатгалын тухай хуулийн 32 дугаар зүйл."Нийгмийн даатгалын шимтгэл ногдуулах хөдөлмөрийн хөлс, түүнтэй адилтгах орлого" ийг мөрдөж ажиллах

6.4 Байгууллагаас өгсөн хариу, тайлбар:

Зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллана

7 Хуулийн хэрэгжилтийн талаар

7.1 Илрүүлэлт:

Тайлант онд нийт 191 компанитай худалдан авалт хийсний 10 компанийн гүйлгээ нь и-баримт цахим хуудсанд мэдээлээгүй байгаа нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13.7.Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг

хориглоно, 20.2.4.нягтлан бодох бүртгэл хөтлөлт нь энэ хууль болон санхүүгийн бусад хууль тогтоомжид заасан шаардлагад нийцэж байгаа эсэхийг хянах гэснийг хэрэгжүүлээгүй байна.

7.2 4.1 Эрсдэл:

Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил гүйлгээг бүртгэл тайланд тусгах

7.3 Өгсөн зөвлөмж:

Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13.7, 20.2.4-ийг мөрдөж ажиллах

7.4 Байгууллагаас өгсөн хариу, тайлбар:

Зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллана

Газар зүй, гео-экологийн хүрээлэнгийн зүгээс зөрчлийг цаашид давтан гаргахгүй ажиллах талаар хариу ирүүлсэн.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2021 оны 06 дугаар сарын 10-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт

Огноо: 2021	Аудитын нэр: Шалгагдсан байгууллагын нэр:	Газар зүй, гео-экологийн хүрээлэн 2020 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудит	Аудитын код: САГ-2021/92/СТА-ТШЗ
		Газар зүй, гео-экологийн хүрээлэн	Мянган төгрөг

№	Алдаа, зөрчлийн товч утга	Мөнгөн дүн	Аудитын байгууллагаас гаргасан шийдэл	Алдаа, зөрчилтэй асуудал гаргасан албан тушаалтны	
			Нэр	Албан тушаал	Овог нэр
	1	2	3	4	5
1	Тайлант оны үндсэн хөрөнгийн элэгдлийн зардлыг санхүүгийн программ илүү тооцож тайланд тусгасан.	5,178.4	Зөвлөмж өгөх	Захирал Ахлах нягтлан бодогч	Д.Баттогтох Б.Лхагвасүрэн
2	Үндсэн хөрөнгөнд элэгдэл хорогдлын шимтгэлээр анхны үнээ нөхсөн 260 нэр төрлийн 886 ширхэн 719,248.5 мянган төгрөгийн хөрөнгө бүртгэлтэй байна	-	Зөвлөмж өгөх	Захирал Ахлах нягтлан бодогч	Д.Баттогтох Б.Лхагвасүрэн
3	Тус байгууллага мөрдөж байгаа хоёр НБББББ байгаа боловч уг бодлого өөрийн үйл ажиллагааны онцлогт тохироогүй байна. Тухайлбал эрдэм шинжилгээний төслийн санхүүжилт болон зарцуулалтыг хэрхэн бүртгэх талаар тусгаж өгөөгүй байна.	-	Зөвлөмж өгөх	Захирал Ахлах нягтлан бодогч	Д.Баттогтох Б.Лхагвасүрэн
4	Автомашинны шатахууны зарцуулалтыг жолоочийн тооцооны хуудсыг үндэслэн тооцоо бодоогүй, мөн хувийн автомашинд байгууллагын шатахууныг зарцуулсан	1,897.0		Захирал Ахлах нягтлан бодогч	Д.Баттогтох Б.Лхагвасүрэн
5	Анхан шатны баримтын бүрдэл дутуу томилолтыг зардалд бүртгэсэн. Үндсэн хөрөнгийн орлого, зарлагын баримт үйлдээгүй, шаардах хуудасгүй бараа материалыг зардалд бичсэн, үндсэн хөрөнгө, бараа материалын тайланг жилд нэг удаа гаргадаг.	7,630.5	Зөвлөмж өгөх	Захирал Ахлах нягтлан бодогч	Д.Баттогтох Б.Лхагвасүрэн
6	Гэрээт ажлын хөлсөөс НДШ суутгаагүй 6,887.5, байгууллага төлөх НДШ-ийг зардал тооцоогүй 7,366.6	14,942.9	Зөвлөмж өгөх	Захирал Ахлах нягтлан бодогч	Д.Баттогтох Б.Лхагвасүрэн
7	Тайлант онд нийт 191 компанитай худалдан авалт хийсний 10 компанийн гүйлгээ нь и-баримт цахим хуудсанд мэдээлээгүй байна		Зөвлөмж өгөх	Захирал Ахлах нягтлан бодогч	Д.Баттогтох Б.Лхагвасүрэн
ДҮН		29,648.8			



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2021 оны 02 дугаар сарын 25

№ 194/А0160058

Улаанбаатар хот

СЭГ-2021/192/СТА-ТЦЗ

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд хийсэн Газар зүй, гео-экологийн хүрээлэнгийн 2020 оны санхүүгийн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

- Тайлант хугацаанд байгууллагын шилэн дансны цахим хуудаст байршуулбал зохих 269 мэдээллээс 81 мэдээллийг хугацаа хоцроосон, 28 мэдээллийг байршуулаагүй байна
Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.3-д "тогтоосон хугацаанд, тогтмол, шуурхай мэдээлдэг байх", 6 дугаар зүйлийн 6.1.2.-т "хагас жилийн төсвийн гүйцэтгэлийг жил бүрийн 08 дугаар сарын 15-ны өдрийн дотор, сар, улирлын гүйцэтгэлийг дараа сарын 08-ны өдрийн дотор"; 6.4.5-д "цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээг гүйлгээ тус бүрээр, гүйлгээний агуулга, хүлээн авагчийн нэр", 6.4.8-д. "..., төсөв, өмч, хөрөнгө, мөнгө зарцуулах, өр, авлага үүсгэсэн аливаа шийдвэр" гэж заасныг тус тус зөрчсөн байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-т "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө" Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох" журмын 4.2.1-д заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

- Шилэн дансны тухай хууль тогтоомжийг хэрэгжүүлж мэдээллийг тогтоосон хугацаанд тогтмол цахим хуудсанд мэдээлж байх, дээрх зөрчлийг арилгах, биелэлтийг 2021 оны 6 дугаар сарын 10-ны дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;
- Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Газар зүй, гео-экологийн хүрээлэнгийн захирал Д.Баттогтох, ерөнхий нягтлан бодогч Б.Лхавгасүрэн нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

АУДИТЫН ХОЁРДУГААР ГАЗРЫН ЗАХИРАЛ,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

Ц.НАРАНЧИМЭГ

АХЛАХ АУДИТОР
"ГРОУТ ФИНАНС АУДИТ" ХХК-ИЙН
ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ

Б.СЭРЖМЯДАГ

Б.БЯМБА



